



**Ард Кредит ББСБ ХК**

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ**

2026

MSE:  ADB

Хүчтэй. Хамтдаа.

# ХУРЛЫН МАТЕРИАЛЫН АГУУЛГА

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоол;
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
3. Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материал
  - 3.1 Ногдол ашиг хуваарилах талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэр;
  - 3.2 Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн танилцуулга;
  - 3.3 Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсвийн төсөл;
  - 3.4 Ард Кредит ББСБ ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлтийн төсөл;
  - 3.5 Компанийн тамга шинэчлэх тухай танилцуулга;
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төсөл

# Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол



КРЕДИТ  
ББСБ

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 3 сарын 17-ны өдөр

№2026/6

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит  
хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.9, 62.1.14 дэх заалт, 65 дугаар зүйлийн 65.1, 65.3, 65.4, 65.5, 65.6 дахь заалт, 67 дугаар зүйлийн 67, 71 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 3 сарын 17-ны өдрийн эцнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг **2026 оны 4 сарын 27-ны өдрийн 11.00 цагт**, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр 17 давхарт байрлах Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн байранд зарлан хуралдуулсугай.
2. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, саналын хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
3. Хурал зарлах тухай мэдэгдлийг 2026 оны 3 сарын 20-ны өдрийн дотор Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржид тус тус хүргүүлсүгэй.
4. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас, өдөр тутмын сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2026 оны 3 сарын 20-ны өдрийн дотор нийтэд мэдээлж, 2026 оны 4 сарын 03-ны өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлсүгэй.
5. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 4 сарын 07-ны өдрөөр тогтоосугай.
6. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, танилцуулга, саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2026 оны 3 сарын 25-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер, дилерийн компаниудад хүргүүлсүгэй.
7. Хурлын даргаар Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ч.Ганзоригийг томилсугай.
8. Дараах нэр бүхий хүмүүсийг Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай.  
Үүнд:



# Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол

Хурал зохион байгуулах комиссын дарга:

Гүйцэтгэх захирал Г.Сүхбаатар

Хурал зохион байгуулах комиссын гишүүд:

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн дарга Г.Есү-Үжин;

Байгууллага хамтын ажиллагаа хариуцсан захирал Б.Пүрэвдорж;

График дизайнер Б.Хадбаатар;

Санхүүгийн менежер Ш.Пүрэвдорж;

Маркетингийн ахлах мэргэжилтэн Б.Бүжин;

Хуульч Б.Отгонбилэг;

Төслийн мэргэжилтэн М.Хэрлэн;

Бүртгэл хяналтын ахлах мэргэжилтэн Ц.Мөнхцэцэг;

Харилцагчийн бүртгэлийн мэргэжилтэн О.Энх-Отгон

9. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2026 оны 4 сарын 24-ний өдрийн 18:00 цагаар тасалбар болгосугай.

10. Хувьцаа эзэмшигчдийг Хурлын материалтай танилцах нөхцөл, боломжийг бүрдүүлж ажиллахыг Хурал зохион байгуулах комиссын дарга Г.Сүхбаатарт даалгасугай.

11. Хурлын Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Тооллогын комиссын дарга:

Ө.Бямбагэрэл (Ард секюритиз ҮЦК ХХК)

Тооллогын комиссын гишүүд:


Ч.Даваацэрэн (Ард секюритиз ҮЦК ХХК)

А.Эрхбилгүүн (Ард секюритиз ҮЦК ХХК)

12. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хурлыг зарлан хуралдуулах, хурлын зар мэдээг хүргэх, хувьцаа эзэмшигчдийг шаардлагатай мэдээллээр хангаж ажиллахыг Хурал зохион байгуулах комиссын дарга Г.Сүхбаатарт даалгасугай.

13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлэхийг хурлын дарга Ч.Ганзориг болон Хурал зохион байгуулах комиссын дарга Г.Сүхбаатар нарт даалгасугай.

ДАРГА




Ч.ГАНЗОРИГ



# Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2026 оны 3 сарын 17-ны өдрийн  
2026/6 тоот тогтоолын Хавсралт №1




## 2026 ОНЫ 4 САРЫН 27-НЫ ӨДӨР ХУРАЛДАХ АРД КРЕДИТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. Компанийн 2025 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
3. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
4. Ногдол ашиг хуваарилах талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрийг танилцуулах;
5. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох;
6. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсвийг батлах;
7. Ард Кредит ББСБ ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
8. Компанийн тамга шинэчлэх;

# Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2026 оны 3 сарын 17-ны өдрийн  
2026/6 тоот тогтоолын Хавсралт №2



## АРД КРЕДИТ ББСБ ХК САНАЛ АВАХ ХУУДАС (ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №5)

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: \_\_\_\_\_  
Регистрийн дугаар: \_\_\_\_\_  
Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн  
Эзэмшиж буй хувьцааны тоо: \_\_\_\_\_

Энэхүү санал авах хуудсаар 2026 оны 4 сарын 27-ны өдрийн 11:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр 17 давхарт байрлах Ард Санхүүгийн нэгдэл ХК-ийн байранд хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

| №                 | ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс | Нэр дэвшигчид өгөх саналын тоо |
|-------------------|--------------------------------------|--------------------------------|
| Ердийн гишүүд     |                                      |                                |
| 1                 |                                      |                                |
| 2                 |                                      |                                |
| 3                 |                                      |                                |
| 4                 |                                      |                                |
| 5                 |                                      |                                |
| 6                 |                                      |                                |
| Хараат бус гишүүд |                                      |                                |
| 1                 |                                      |                                |
| 2                 |                                      |                                |
| 3                 |                                      |                                |

1. Санамж: ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана. Тус арга нь санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. Жишээ нь: та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байхад үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон тохиолдолд Хувьцаа эзэмшигч эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй ( $100 \times 9 \text{ гишүүн} = 900$ ) болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно гэдгийг анхаарна уу. Хувьцаа эзэмшигч нь хувь хүн бол саналын хуудас дээр гарын үсэг

## Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол

зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол эрх бүхий этгээд гарын үсэг зурж болон хуулийн этгээдийн тэмдгийг дарж баталгаажуулсан байна.

2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр, 1 давхарын салбарт ирж хурлын материалтай танилцан санал авах хэвлэмэл хуудас, эсвэл Ард Апп дахь санал авах хуудсаар дамжуулан урьдчилан саналаа өгнө.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл олгож, нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.
4. Хувьцаа эзэмшигч нь хувь хүн бол саналын хуудас дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол эрх бүхий этгээд гарын үсэг зурж болон хуулийн этгээдийн тэмдгийг дарж баталгаажуулсан байна

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг \_\_\_\_\_

Санал авах хуудсыг үйлдсэн 2026 оны .. сарын .. өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй


Тооллогын комиссын дарга \_\_\_\_\_ /...../

Хүчингүйд тооцсон бол шалтгаан: \_\_\_\_\_



# Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2026 оны 3 сарын 17-ны өдрийн  
2026/6 тоот тогтоолын Хавсралт №2



**АРД КРЕДИТ ББСБ ХК  
САНАЛ АВАХ ХУУДАС  
(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №3, 6, 7, 8)**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: \_\_\_\_\_  
Регистрийн дугаар: \_\_\_\_\_  
Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн  
Эзэмшиж буй хувьцааны тоо: \_\_\_\_\_

Энэхүү санал авах хуудсаар 2026 оны 4 сарын 27-ны өдрийн 11:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр 17 давхарт байрлах Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн байранд хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.


| № | Хурлаас гарах шийдвэрийн томъёолол                                                                                           | Зөвшөөрсөн               | Татгалзсан               | Түдгэлзсэн               |
|---|------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|--------------------------|--------------------------|
| 1 | Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 2 | Ард Кредит ББСБ ХК-ийн дүрмийн 1.4-т өөрчлөлт оруулан шинэчилсэн найруулгыг батлах;                                          | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 3 | Компанийн тамга шинэчлэх;                                                                                                    | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 4 | Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсвийг батлах;                                                                          | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдгийг бичнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр 1 давхарын салбарт ирж хурлын материалтай танилцан санал авах хэвлэмэл хуудас, эсвэл Ард Апп дахь санал авах хуудсаар дамжуулан урьдчилан саналаа өгнө.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл олгож, нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.
4. Хувьцаа эзэмшигч нь хувь хүн бол саналын хуудас дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол эрх бүхий этгээд гарын үсэг зурж болон хуулийн этгээдийн тэмдгийг дарж баталгаажуулсан байна

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг \_\_\_\_\_  
Санал авах хуудсыг үйлдсэн 2026 оны .. сарын .. өдөр  
Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй  
Тооллогын комиссын дарга \_\_\_\_\_ /...../  
Хүчингүйд тооцсон бол шалтгаан: \_\_\_\_\_

# Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2026 оны 3 сарын 17-ны өдрийн  
2026/6 тоот тогтоолын Хавсралт №3



## АРД КРЕДИТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Ард Кредит ББСБ ХК нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулахаар боллоо. Хувьцаа эзэмшигч та хурлын өдөр Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр 17 давхарт байрлах Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн байранд ирж хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаа оролцоно уу.

**Компанийн оноосон нэр:** Ард Кредит ББСБ ХК

Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 2026/6 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах тухай зарлаж байна.

**Хурал хуралдуулах өдөр, цаг, байршил:** 2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 11:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр 17 давхарт байрлах Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн байранд хуралдана.

**Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Үүнд:**

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. Компанийн 2025 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
3. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
4. Ногдол ашиг хуваарилах талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрийг танилцуулах;
5. ТУЗ-ийн гишүүдийг сонгох;
6. ТУЗ-ийн 2026 оны төсвийг батлах;
7. Ард Кредит ББСБ ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
8. Компанийн тамга шинэчлэх;

**Бүртгэлийн өдөр:** 2026 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр

**Хуралд бэлтгэх явцад Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт:**

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;
2. ТУЗ-ийн Ногдол ашиг хуваарилах тухай тогтоол;
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нэр дэвшигчдийн танилцуулга;
4. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх, саналын хуудасны загвар;
5. Ард Кредит ББСБ ХК-ийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлт;
6. Хувьцаа эзэмшигчийн хурлын тогтоолын төсөл;

Хувьцаа эзэмшигч та өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол **2026 оны 4 сарын 24-ний өдрөөс өмнө ажлын өдрүүдэд 09:00-18:00 цагийн хооронд** Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сүхбаатарын талбай 2, Сэнтрал тауэр барилгын 1 давхарт ирж, эсвэл компанийн [www.ardcredit.com](http://www.ardcredit.com)

# Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол

цахим хуудсаар хурлын материалтай танилцаад санал авах хэвлэмэл хуудас, эсвэл Ард Апп дахь санал авах хуудсаар дамжуулан урьдчилан саналаа өгнө.

Хурлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг компанийн байранд болон хурал зохион байгуулах комиссын утсаар холбогдон авна уу.

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 хороо, Соёл амралтын хүрээлэн (14240), Энхтайвны өргөн чөлөө, 17 дугаар барилга, 9 дүгээр давхар.


Утас: 77003322

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС



# Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2026 оны 3 сарын 17-ны өдрийн  
2026/6 тоот тогтоолын Хавсралт №4



## 2026 ОНЫ 4 САРЫН 27-НЫ ӨДӨР ХУРАЛДАХ

### АРД КРЕДИТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ МАТЕРИАЛ

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн Ногдол ашиг хуваарилах тухай тогтоол;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшигчдийн танилцуулга;
4. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх, саналын хуудасны загвар;
5. Ард Кредит ББСБ ХК-ийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлт;
6. Хувьцаа эзэмшигчийн хурлын тогтоолын төсөл;

# Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг

## АРД КРЕДИТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

“Ард Кредит ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 11 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр 17 давхарт байрлах Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн байранд

|    | Хэлэлцэх асуудал                                                                                                            | Хугацаа     | Хариуцах                                                            |
|----|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|---------------------------------------------------------------------|
| 1  | Хурлын ирц бүртгэх, ирцийг мэдээлэх                                                                                         | 11:00-11:05 | Тооллогын комиссын дарга<br>Ө.Бямбагэрэл                            |
| 2  | Хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээх, хурлын дэг танилцуулах                                                                    | 11:05-11:10 | Хурлын дарга Ч.Ганзориг                                             |
| 3  | Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;                                                    | 11:10-11:25 | Гүйцэтгэх захирал Г.Сүхбаатар                                       |
| 4  | Компанийн 2025 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;                      | 11:25-11:30 | Хөндлөнгийн аудитын “Нексна Глобал Монголиа Аудит” ХХК-ийн төлөөлөл |
| 5  | Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах; | 11:30-11:35 | ТУЗ-ийн Хараат бус гишүүн<br>С.Энхчимэг                             |
| 6  | Ногдол ашиг хуваарилах талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрийг танилцуулах;                                           | 11:35-11:40 | Хурлын дарга Ч.Ганзориг                                             |
| 7  | Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшигчдийг танилцуулах;                                                           | 11:40-11:45 | Хурлын дарга Ч.Ганзориг                                             |
| 8  | Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсвийг батлах;                                                               | 11:45-11:50 | Хурлын дарга Ч.Ганзориг                                             |
| 9  | Хэлэлцэх асуудлуудтай холбоотой асуулт, хариулт                                                                             | 11:50-12:15 | Хурлын дарга Ч.Ганзориг, ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал,         |
| 10 | Хэлэлцэж байгаа асуудлаар санал хураах                                                                                      | 12:15-12:25 | Тооллогын комиссын дарга<br>Ө.Бямбагэрэл                            |
| 11 | Санал хураалтын дүнг нэгтгэн танилцуулах, Тооллогын комиссын тогтоолыг батлуулах                                            | 12:25-12:30 | Тооллогын комиссын дарга<br>Ө.Бямбагэрэл                            |
| 12 | Хурлаас гарсан шийдвэрийг хурлын дарга танилцуу, батлуулах, хурлыг хаах                                                     | 12:30-12:35 | Хурлын дарга Ч.Ганзориг                                             |

### Тооллогын комиссын бүрэлдэхүүн:

Тооллогын комиссын дарга:

Ө.Бямбагэрэл (Ард секюритиз YЦК ХХК)

Тооллогын комиссын гишүүд:

Ч.Даваацэрэн (Ард секюритиз YЦК ХХК)

А.Эрхбилгүүн (Ард секюритиз YЦК ХХК)

# Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материал



КРЕДИТ  
ББСБ

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 02 сарын 16-ны өдөр

№ 2026/5

Улаанбаатар хот

### Ногдол ашиг хуваарилах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2 дахь, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, Компанийн “Ногдол ашгийн бодлого”-ын 2 дугаар зүйлийн 2.2, 2.3 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн эчнээ шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгийн 25% (хорин тав) буюу 1,106,560,000 (нэг тэрбум нэг зуун зургаан сая таван зуун жаран мянга) төгрөгийг нэгж хувьцаанд 3.04 (гурван төгрөг дөрвөн мөнгө) төгрөгөөр тооцож, ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр хуваарилахыг зөвшөөрсүгэй.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах бүртгэлийн өдрийг 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тасалбар болгон тогтоосугай.
3. Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахтай холбоотой төлбөр тооцоог “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр олгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох гэрээ хэлэлцээр байгуулж гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатар)-т олгож, тогтоосон хугацаанд хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахыг үүрэг болгосугай.
5. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг Монголын Хөрөнгийн биржид зохих журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Г.Есү-Үжин)-д даалгасугай.
6. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод аудитын хороо (В.Ганзориг)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНЗОРИГ



Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдийн  
танилцуулга



Нэр дэвшигч

# Хүрэлбаатарын Билгүүн

## Боловсрол

- 2008–2013 МУИС, Олон Улсын Эдийн Засгийн Онол, Бакалавр
- 2014–2018 МУИС, Эдийн Засгийн Онол, Магистр
- 2020–2021 University of Glasgow (Шотланд), MSc Financial Forecasting & Investment, Магистр

## Ажлын туршлага

- 2017-2019 Санхүүгийн Зохицуулах Хороо, Ахлах референт
- 2019–2020 Мөнхбумууд ХХК, Санхүү эрхэлсэн захирал
- 2021–2023 Ард Кредит ББСБ ХК, Санхүү эрхэлсэн захирал
- 2022–2023 Азийн Хөгжлийн Банк, Ахлах зөвлөх
- 2022–2024 Ард Секюритиз ҮЦК ХХК, ТУЗ-ийн дарга
- 2023–2024 Ард Санхүүгийн Нэгдэл ХК, Санхүү эрхэлсэн захирал
- 2025–Одоог хүртэл Санхүүгийн Зохицуулах Хороо, Үнэт цаасны зах зээлийн бодлогын зөвлөлийн гишүүн

## Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдийн танилцуулга



Нэр дэвшигч

# Одончимэдийн Одбаяр

### Боловсрол

- 1984-1988 ЗХУ-ын Киев хот Багшийн их сургууль, Бакалавр
- 1996-1997 АНУ-ын Флоридагийн Техникийн Их Сургуульд эдийн засагч
- 1997-2000 Отгонтэнгэр Их Сургуульд хуульч, эрх зүйч мэргэжлээр магистр,
- 2017-2018 АНУ-ын Бостон хотын Харвардын Их Сургуульд удирдлагын чиглэлээр мэргэшин суралцсан;
- 2019 онд Лондонгийн Оксфортын их сургуулийн Байгалийн баялгын засаглалын чиглэлээр мэргэшин суралцсан.

### Ажлын туршлага

- 2000-2002 Монгол-Хятадын хамтарсан "Си Эм Эйч" ТӨК, монголын талын Гүйцэтгэх захирал
- 2002-2004 "МИАТ" ХК, Бээжин дэх төлөөлөгч
- 2005-2010 Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны Атташе, Гуравдугаар нарийн бичгийн дарга
- 2010-2012 Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх
- 2012-2016 "Алтай Холдинг" ХХК, Дэд ерөнхийлөгч
- 2012-2016 "Чингис Хаан зочид буудал цогцолбор" ХХК, Гүйцэтгэх захирал
- 2016-2018 "Эрдэнэс Стийл" ХХК, ТУЗ-ийн дарга
- 2016-2019 "Эрдэнэс Монгол" ХХК, Дэд захирал
- 2016-2020 "Бадрах Энержи" ХХК, ТУЗ-ийн гишүүн
- 2017-одоог хүртэл Ард Санхүүгийн нэгдэл ХК, ТУЗ-ийн гишүүн
- 2018-одоог хүртэл Ард Кредит ББСБ ХК, ТУЗ-ийн гишүүн
- 2018-2020 "Таван толгой түлш" ХХК, ТУЗ-ийн гишүүн
- 2020-одоог хүртэл АПУ ХК, ТУЗ-ийн гишүүн
- 2021-одоог хүртэл Ард даатгал ХК, ТУЗ-ийн дарга

## Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдийн танилцуулга



Нэр дэвшигч

# Чулууны Ганзориг

### Боловсрол

- 2005–2007 Шанхайн их сургууль (БНХАУ), Хятад хэлний анги
- 2007–2010 Корвинусын их сургууль (Унгар), Бизнес менежментийн бакалавр

### Ажлын туршлага

- 2010-2012 одоогийн Ард Секюритиз ҮЦК, хөрөнгө оруулалтын шинжээч
- 2012-2013 Ард Санхүүгийн Нэгдэл ХК, хөрөнгө оруулалтын мэргэжилтэн
- 2013-2019 Ард Кредит ББСБ ХК, Гүйцэтгэх захирал
- 2017-2018 Ард Санхүүгийн Нэгдэл ХК, Санхүү эрхэлсэн захирлаар давхар ажиллаж байсан.
- 2022-2026 Айдакс ХХК, Гүйцэтгэх захирал,
- 2022-одоог хүртэл Ард Кредит ББСБ ХК, ТУЗ-ийн даргаар ажиллаж байна



## Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдийн танилцуулга



Нэр дэвшигч

# Мөнхбатын Мөнх-Эрдэнэ

### Боловсрол

- 2007–2011 Мандах бүртгэл их сургууль, Банкны эдийн засагч, нягтлан бодогч, бакалавр
- Мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Мэргэшсэн нягтлан бодогч (CPA of Mongolia)
- Татварын мэргэшсэн зөвлөх (CPTA of Mongolia)

### Ажлын туршлага

- 2011-2014 АПУ ХК болон аудитын Хүлэгт Хүннү аудит ХХК-д
- 2016-одоог хүртэл Ард Санхүүгийн Нэгдэл ХК, Дотоод аудит эрхэлсэн захирал
- 2024-одоог хүртэл Ард Кредит ББСБ ХК, ТУЗ-ийн Ердийн гишүүн ажиллаж байна.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдийн  
танилцуулга



Нэр дэвшигч

**Галнямын  
Уянга**

Боловсрол

- 1998- 2002 Санхүү эдийн засгийн их сургуулийг Банк, санхүүч, бакалавр

Ажлын туршлага

- 2005-2009 НҮБ төсөл, Грассрүүтс Жижиг дунд бизнесийг дэмжих төв, Гүйцэтгэх захирал;
- 2009-2019 Арван гэрийн холбоо ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2019- одоог хүртэл Ард Пропертиз ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2024-2026 Ард Санхүүгийн Нэгдэл ХК, Үйл ажиллагаа эрхэлсэн захирал
- 2023-одоог хүртэл Ард Кредит ББСБ ХК, ТУЗ-ийн Ердийн гишүүн ажиллаж байна.
- 2026-оноос эхлэн Ард Санхүүгийн Нэгдэл ХК, Ерөнхий захирал

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдийн  
танилцуулга



Нэр дэвшигч

# Гүррагчаагийн Сүхбаатар

## Боловсрол

- 2000–2004 Монгол Улсын Их Сургууль, Нягтлан бодогч, бакалавр
- 2019–2020 Бизнесийн удирдлагын магистр (MBA)

## Ажлын туршлага

- 2005-2006 Хасбанк ХК, Эдийн засагч;
- 2006-2016 Хасбанк ХК салбарын захирал;
- 2017-2019 Ард Кредит ББСБ ХК, Зээлийн менежер;
- 2019-2024, Ард Кредит ББСБ ХК, Гүйцэтгэх захирлын орлогч, Үйл ажиллагаа эрхэлсэн захирал
- 2024-одоог хүртэл Ард Кредит ББСБ ХК, Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн Ердийн гишүүн ажиллаж
- 2024-одоог хүртэл Монголын Банк бус санхүүгийн байгууллагын холбооны удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна.



## Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн танилцуулга



Нэр дэвшигч

# Ванчигийн Ганзориг

### Боловсрол

- 1997.09–2001.06 Худалдаа Үйлдвэрлэлийн Дээд Сургууль, Бизнесийн Удирдлага, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр бакалавр
- 2003.02–2004.12 Нотр Дэймийн Их Сургууль (Австрали), Бизнесийн Удирдлагын Мастер (MBA)
- 2009.09–2010.08 Япон Улсын Олон Улсын Их Сургууль (Япон), Цахим Бизнесийн Удирдлагын Мастер (Master of E-Biz)
- 2014.11 Йэлийн Их Сургууль (АНУ), "21-р зууны манлайлал ба шийдвэр гаргалт" ахисан шатны хөтөлбөр
- 2015.07 Оксфордын Их Сургууль (ИБУИНВУ), "Өөрчлөлтийг удирдахуй" ахисан шатны хөтөлбөр
- 2016.11 Вицвотерсрандийн Их Сургууль (ӨАБНУ), "Өөрчлөлтийн манлайлал" ахисан шатны хөтөлбөр
- 2017.10 Сингапурын Үндэсний Их Сургууль (Сингапур), "Бодлогын инноваци, гео улс төр" ахисан шатны хөтөлбөр
- 2018.11 Кэйп Тауны Их Сургууль (ӨАБНУ), "Өөрчлөлтийн удирдлага" ахисан шатны хөтөлбөр
- 2021.06 Виржиниагийн Их Сургууль (АНУ), "Нийгмийн тэгш боломж" нийгмийн манлайллын ахисан шатны хөтөлбөр

### Ажлын туршлага

- 2000-2002 Галт Гарьд Холдинг ХХК, Эдийн засагч, нягтлан бодогч
- 2002–2003 Худалдаа Үйлдвэрлэлийн Дээд Сургууль, Эдийн засаг, менежментийн тэнхимд багш
- 2005–2007 Худалдаа Хөгжлийн Банк ХХК, Бүтээгдэхүүн хөгжлийн менежер, Банкны ахлах ажилтан
- 2007–2009 ХасБанк ХК, Дэд ерөнхийлөгч, Маркетингийн газрын захирал
- 2010–2012 Шунхлай Групп, Дэд ерөнхийлөгч, Стратеги төлөвлөлт хариуцсан захирал
- 2010–Одоог хүртэл Шунхлай Групп, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Телеком ба медиа бизнес группын тэргүүн
- 2012.05–2015.10 Медиа Групп, Гүйцэтгэх захирал
- 2015–Одоог хүртэл Бат Солюшн Партнерс ХХК, ТУЗ-ийн дарга
- 2019-оноос одоог хүртэл Ард Кредит ББСБ ХК, ТУЗ-ийн Хараат бус гишүүн

## Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн танилцуулга



Нэр дэвшигч

# Батсүрэнгийн Солонго

### Боловсрол

- 2006-2011 онд ОХУ-ын Москва хотын Санхүүгийн дээд сургуулийг санхүүч
- 2017-2018 онд Удирдлагын академи, Бизнес удирдлагын магистр

### Ажлын туршлага

- 2011-2012 Софтлайн Азия ХХК, Маркетингийн менежер
- 2012-2015 Софтлайн Азия ХХК, Худалдаа, маркетинг хариуцсан захирал
- 2015-одоог хүртэл Триквест ХХК-ийн Гүйцэтгэх захирал
- 2015-2020 Софтлайн Азия ХХК, Гүйцэтгэх захирал
- 2016-2019 Ард Санхүүгийн Нэгдэл ХК, ТУЗ-ийн хараат бус гишүүн
- 2021-2024 - МУК ХХК-ийн Гүйцэтгэх захирал
- 2021-одоог хүртэл Ард Кредит ББСБ ХК, ТУЗ-ийн хараат бус гишүүн

## Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн танилцуулга



Нэр дэвшигч

# Сүхбаатарын Энхчимэг

### Боловсрол

- 2004–2008 Улаанбаатар дээд сургууль, Үйлдвэрлэлийн инженер дизайн
- 2008–2010 Жонжу Их сургууль (БНСУ), Үйлдвэрлэлийн инженер дизайн
- 2011–2013 Жонжу Их сургууль (БНСУ), Бизнесийн менежментийн магистр

### Ажлын туршлага

- 2011–2012 Скайтел ХХК, Хэвлэл, олон нийтийн харилцааны менежер
- 2012–2014 Скаймедиа ХХК, Брэнд менежер
- 2014–Одоог хүртэл Нахауз крейтив ХХК, Үүсгэн байгуулагч, Хувьцаа эзэмшигч
- 2015–2016 Нахауз крейтив ХХК, Дэд захирал
- 2017–2022 Эрдэнэс Монгол ТӨХК, Бизнес хөгжлийн мэргэжилтэн
- 2023 Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨҮГ, Гүйцэтгэх захирал
- 2023–Одоог хүртэл Ард Кредит ББСБ ХК, ТУЗ-ийн Хараат бус гишүүн



## Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн танилцуулга



Нэр дэвшигч

# Төмөртоогогийн Булган

### Боловсрол

- 2007–2011 Мандах Бүртгэл Их Сургууль, Банкны эдийн засаг, нягтлан бодох бүртгэл
- 2016–2018 Да-Ех Их Сургууль (Тайвань), Бизнесийн удирдлагын магистр (MBA)
- 2017 Talent Management LLC, 3-р түвшний батламжит сургалтын багш
- 2019 House of Training (Люксембург), Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр
- 2019 НҮБ-ын Терроризмтой тэмцэх алба, FATF Recommendation 8, AML principles
- 2022 CMC-Global, ISO 20700: Зөвлөх үйлчилгээний стандарт менежмент
- 2024 Punyam Academy, ISO 37301 стандартын тэргүүлэх аудиторын сертификат

### Ажлын туршлага

- 2011–2016 Голомт Банк ХК, Харилцагчийн менежер
- 2018–2022 Капитрон Банк ХХК, Ахлах комплаенс менежер, Тогтвортой санхүүгийн ажилтан
- 2022–одоог хүртэл Буби консалтинг ХХК, Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч
- 2023–2025 Ариг Банк ХХК, Комплаенсын хэлтсийн захирал

# Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсвийн төсөл

| Төлөөлөн Удирдах Зөвлөл      | Гишүүдийн тоо | Сар | Нэг сарын цалин | 2026 төсвийн санал /төгрөг/ |
|------------------------------|---------------|-----|-----------------|-----------------------------|
| Үндсэн цалин                 |               |     |                 | 123,780,000                 |
| ТУЗ дарга                    | 1             | 12  | 1,495,000.00    | 17,940,000                  |
| Хорооны дарга                | 4             | 12  | 1,150,000.00    | 55,200,000                  |
| ТУЗ-ийн гишүүн               | 4             | 12  | 805,000.00      | 38,640,000                  |
| ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга | 1             | 12  | 1,000,000.00    | 12,000,000                  |
| Урамшуулал                   |               |     |                 | 55,890,000,                 |
| Сургалт, хурлын зардал       |               |     |                 | 13,500,000                  |
| Нийт                         |               |     |                 | 193,170,000                 |

## Ард Кредит ББСБ ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлтийн төсөл болон компанийн тамгыг шинэчлэх

| Дүрмийн заалт | Өмнөх зохицуулалт                                                                                                                                                                                                                                                                | Өөрчлөхөөр санал оруулж буй зохицуулалт                                                                                                         |
|---------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1.4           | Компани нь Хүчтэй.Хамтдаа. гэсэн уриа үгтэй байх бөгөөд компанийн бэлгэдэл тэмдэг нь  КРЕДИТ ББСБ байх ба АРД гэсэн улаан гурван үсгээс бүрдсэн байх ба хажууд нь Кредит ББСБ гэж бичсэн байна. | Компани нь Хүчтэй.Хамтдаа. <b>Ard</b> гэсэн уриа үгтэй байх бөгөөд компанийн бэлгэдэл тэмдэг нь байх ба хажууд нь Кредит ББСБ гэж бичсэн байна. |

Ард Кредит ББСБ ХК-ийн брэнд төрх шинэчлэгдэж, компанийн лого өөрчлөгдсөнтэй холбогдуулан одоо ашиглагдаж буй тамгыг хураалгаж, тамганы хяналтын дугаар шинээр авах шаардлага үүссэн.



# Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төсөл



## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

2026 оны 4 сарын 27-ны өдөр

№2026/01

Улаанбаатар хот

Компанийн 2025 оны Үйл ажиллагааны болон санхүүгийн  
тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь заалт, 2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын ..... тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Ард Кредит ББСБ” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны ..... дүгээр сарын .....-ны өдрийн 2026/..... тогтоолоор гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрч баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ГАНЗОРИГ

# Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төсөл



## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

2026 оны 4 сарын 27-ны өдөр

№2026/02

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн  
 гишүүдийг сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.1, 77.2 дахь заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалт, 2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын ..... тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр дараах нэр дэвшигчдийг сонгосугай.
  - 1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн Ердийн гишүүд:
    - 1.1.1. Хүрэлбаатарын Билгүүн;
    - 1.1.2. Чулууны Ганзориг;
    - 1.1.3. Мөнхбатын Мөнх-Эрдэнэ;
    - 1.1.4. Одончимэдийн Одбаяр;
    - 1.1.5. Галнямын Уянга;
    - 1.1.6. Гүррагчаагийн Сүхбаатар;
  - 1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүд:
    - 1.2.1. ....;
    - 1.2.2. ....;
    - 1.2.3. ....;
2. Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа 3 (гурав) жилийн хугацаатай бөгөөд ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрөөр дуусгавар болохыг дурдсугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлж, зохих зөвшөөрлийг авч ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга (Г.Есү-Үжин)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ГАНЗОРИГ

# Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төсөл



## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

2026 оны 4 сарын 27-ны өдөр

№2026/03

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026  
оны төсөв батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь заалт, 2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын ..... тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсвийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ГАНЗОРИГ



# Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төсөл



## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

2026 оны 4 сарын 27-ны өдөр

№2026/05

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай

Монгол улсын омпанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь заалт болон 2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын .. тоот тогтоолыг дүнг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн брэнд төрх шинэчлэгдэж, компанийн лого өөрчлөгдсөнтэй холбогдуулан дүрмийн 1.4 дэх заалтад өөрчлөлт оруулсугай.
2. Энэхүү шийдвэрийн 1 дэх хэсэгт заасан нэмэлт, өөрчлөлт оруулсан Компанийн дүрмийг хавсралтаар баталсугай.
3. Энэхүү шийдвэрийн хавсралтаар баталсан Компанийн дүрмийг хууль, тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, холбогдох бусад байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатар)-т даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ГАНЗОРИГ

# Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төсөл



## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

2026 оны 4 сарын 27-ны өдөр

№2026/05

Улаанбаатар хот

Компанийн тамгыг шинэчлэн  
солиулах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь хэсэг, , 2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын ..... тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн брэнд төрх шинэчлэгдэж, компанийн лого өөрчлөгдсөнтэй холбогдуулан одоо ашиглагдаж буй тамгыг хураалгаж, тамганы хяналтын дугаар шинээр авахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангуулж холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатарт)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ГАНЗОРИГ